# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2024 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/148 Улаанбаатар хот

Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээний 2024-2027 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5, 8.1.6 дахь заалт, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.2.1 дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээний 2024-2027 оны төлөвлөгөөг нэгдүгээр, төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн удирдлага, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар /А.Өнөржаргал/-т, Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т, салбарын бодлого, хөтөлбөрт тусгахыг Бодлого, төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг)-т, шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан)-т, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газарт, хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, олон улсын дэмжлэг авч ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /В.Баярмаа/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаж өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын тайланг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т ирүүлж байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн тусгай мэргэшлийн төв бусад холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД С.ЧИНЗОРИГ

141240586

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 сарын 29 өдрийн А/118 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# “СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД” АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024-2027 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:**
Хөтөлбөрийн зорилго нь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, нийгэм, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хянах, бэхжүүлэх, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.

**Зорилт:**

1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль, эрх зүйн орчин, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах;
2. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх, нийгэм, хамт олонд түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах;
3. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, өргөжүүлэх;
4. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг олон улсын жишигт нийцүүлэн сургах, хөгжүүлэх, мэргэшүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Төсөв (сая) | Суурь түвшин 2023 он | Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая.төгрөг) | | | | | | | | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2024 | | 2025 | | 2026 | | 2027 | | | |
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Үндсэн | Хамтрагч |
| **1. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, САЛБАР ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | | | | | | | | | |
| 1. | "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, УИХ-аар батлуулах | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | - | "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай" хууль /2013 он/ | Хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэлэлцүүлсэн байна | - | "Сэтгэцийн эрүүл мэндийн тухай" хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-аар батлуулсан байна | - | Хуулийн хэрэгжиж эхэлсэн байна | - | Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн байна | - | ЭМЯ-ны БТГ, НЭМГ, СЭМҮТ | Холбогдох яамд |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Сэтгэцийн эмгэг, амиа хорлох оролдлого хийсэн, мансууруулах бодис хэрэглэсэн болон донтох эмгэгийг бүртгэн улсын хэмжээний нэгдсэн тайлан мэдээ гаргах цахим мэдээллийн сан ажиллуулах | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 250.0 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль 7.3.3, Тогтвортой хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлт 3.4.2, 3.5.1 | Мэдээллийн нэгдсэн цахим сангийн ажиллах журмын төслийг боловсруулж 3 сайдын хамтарсан тушаалаар батлуулсан байна | 150.0 | Сэтгэцийн эмгэгийн талаар улсын хэмжээний нэгдсэн тайлан мэдээ гаргахад дэмжлэг үзүүлж 3 бүсийн аймгуудын эмч, мэргэжилтнүүдэд сургалтыг явуулсан байна | 50.0 | Сэтгэцийн эмгэгийн талаар улсын хэмжээний нэгдсэн тайлан мэдээ гаргахад дэмжлэг үзүүлж бүсчилсэн 2 бүсийн аймгуудын эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалтыг явуулсан байна | 50.0 | Сэтгэцийн эмгэгийн талаар тайлан мэдээ гаргахад удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангаж, лавлагааны санд хяналт тавьж ажилладаг болсон байна | - | ХЗДХЯ ЦХХХЯ ЭМЯ-ны БТГ, ГХУСАЗЗАА ЭМХТ СЭМҮТ ЭЭХХЗГ Аймаг, нийслэлийн ЭМГ | ХНХЯ, ЦЕГ БЕГ, НБГ, БМДИ, |
| 3. | Согтууруулах ундааны хэрэглээг бууруулах ДЭМБ-аас "Аюулгүй" арга хэмжээ санаачилгыг дэмжих, нутагшуулах төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 95.0 | - | "Аюулгүй" багц согтууруулах ундааны хэрэглээг нутагшуулах стратеги төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлж эхэлсэн байна | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 30% хүрсэн байна | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 60% хүрсэн байна | 65.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт 90% хүрсэн байна | 30.0 | ЭМЯ, ХЗДХЯ, СЯ, ХХААХҮЯ ХНХЯ Аймаг, нийслэлийн бүх гатны Засаг дарга | СЭМҮТ НЭМҮТ |
| 4. | Архидан согтуурах, мансуурах, донтох зэрэг сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм, орчны сөрөг хүчин зүйлээс сэргийлэх, эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, хэм хэмжээ, хууль тогтоомжийг мөрдөх арга хэмжээг зохион байгуулах | 2024-2025 | Улсын төсөв ОУБ | 500.0 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5.1.1 | Архидан согтуурах, мансуурах, донтох эмгэгээс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулсан байна | 50.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт 45%-д хүрсэн байна | 150.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт 75%-д хүрсэн байна | 150.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт 95%-д хүрсэн байна | 150.0 | ХЗДХЯ, ХХААХҮЯ ЭМЯ-ны СХГ, СЭМҮТ Бүх шатны Засаг дарга | Төрийн болон ТББ |
| 5. | Хэвтүүлэн эмчлэх болон эмнэл зүйн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сэтгэцийн эмнэлэг, аймаг, дүүргийн эмнэлэгт бий болгох, сургууль, хамт олны түвшинд сэтгэл зүйч, нийгмийн ажилтны баг бүрдүүлж ажиллуулах | 2024-2025 | Улсын төсөв ОУБ | 500.0 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5.1.3 | Сэтгэцийн эмнэлэг, аймаг, дүүргийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилж эмнэл зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх жижиг төв, тасаг, нэгжийг байгуулах суурь судалгааг хийж, хүний нөөцийг бэлтгэсэн байна | 50.0 | Дүүргийн 2, баруун бүсийн 2 аймагт хэвтүүлэн эмчлэх болон эмнэл зүйн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны багийг бүрдүүлсэн байна | 150.0 | Зүүн бүсийн 2 аймаг, 2 дүүрэгт хэвтүүлэн эмчлэх болон эмнэл зүйн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны багийг бүрдүүлсэн байна | 150.0 | Төвийн бүсийн 3 аймаг, 1 дүүрэгт хэвтүүлэн эмчлэх болон эмнэл зүйн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, сэтгэл зүйч, нийгмийн ажилтны багийг бүрдүүлсэн байна | 150.0 | ЭМЯ-ны БТГ, ЭТҮГ СЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ | Төрийн болон ТББ |
| 6. | Тамхины хяналтын суурь конвенцыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 95.0 | ТХСК, Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө /2022 он/ | Тамхины хэрэглээг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төслийг батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн байна | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 40%-д хүрсэн байна | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 60%-д хүрсэн байна | 65,0 | Төлөвлөгөөний хэрэгжилт 85%-д хүрсэн байна | 30.0 | ХЗДХЯ ХХААХҮЯ ЦХХХЯ, СЯ, ЭМЯ-ны БТГ, НЭМГ | АНЗДТГ АНЭМГ СЭМҮТ НЭМҮТ |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Амиа хорлолтын түвшинг үр дүнтэй бууруулах төлөвлөгөө боловсруулж, батлуулах | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | - | - | Амиа хорлолтын түвшинг үр дүнтэй бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулан хэрэгжүүлж эхэлсэн байна. | | Төлөвлөгөөний хэрэгжилт 40%-д хүрсэн байна | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 60%-д хүрсэн байна | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 80%-д хүрсэн байна | - | ХЗДХЯ ЭМЯ ХНХЯ ЦХХХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ | БХБЯ СЭМҮТ НЭМҮТ АШУҮИС |
| 8. | Олон улсын өвчний XI дүгээр ангиллыг нэвтрүүлэх | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 290.0 | - | Олон улсын өвчний XI дүгээр ангиллыг нэвтрүүлж, гарын авлага хэвлэгдсэн байна. | 60.0 | Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний 20 хувийг сургалтад хамруулсан байна. | 40.0 | Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний 60 хувийг сургалтад хамруулсан байна. | 90.0 | Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний 90 хувийг сургалтад хамруулсан байна. | 100.0 | ЭМЯ-ны БТГ, ЭТҮГ СЭМҮТ ЭМДЕГ | СЭМҮТ, АШУҮИС |
| 9. | Албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг байгууллагын дотоод дүрэм, журам, хамтын гэрээнд тусган мөрдөж ажиллах, хамт олныхоо сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 246.0 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 6.1.1 | Ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн төлөвлөгөөг баталж, 50 байгууллагад хэрэгжүүлсэн байна | | Төлөвлөгөөний хэрэгжилт 30%-д хүрч, 100 байгууллагад арга хэмжээг зохион байгуулсан байна | - | Төлөвлөгөөний хэрэгжилт 60%-д хүрч, 200 байгууллагад арга хэмжээг зохион байгуулсан байна | 200.0 | Төлөвлөгөөний хэрэгжилт 90%-хүрч, 300 байгууллагад арга хэмжээг зохион байгуулсан байна | - | Бүх яам, Бүх шатны Засаг дарга | НЭМҮТ, СЭМҮТ, ЭМБ |
| 10. | Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, сэтгэцийн эмгэгтэй хүнийг дэмжих үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 1000.0 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйл | Хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч/ нь тогтоогдоогүй, иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай сэтгэцийн эмгэгтэй хүний судалгаа гаргасан байна | 30.0 | Иргэний эрх зүйн чадамжгүй сэтгэцийн эмгэгтэй хүний эмчилгээ, үйлчилгээнд хяналт тавьж, үнэлэх, зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байна | 30.0 | Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгох, асрамж, үйлчилгээнд хамруулах асуудлыг эрх бүхий байгууллага, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна | 40.0 | Гэр бүлийн тухай хуулийн 63, 64 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагын дэмжлэгтэйгээр асрамжийн үйлчилгээний төвийг байгуулсан байна. | 900.0 | ХНХЯ СЯ ХЗДХЯ ЭМЯ-ны БТГ, ЭТҮГ, СЭМҮТ | Хүний эрхийн үндэсний комисс Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга |
| | 2. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ, ДЭМЖИХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, НИЙГЭМ, ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭСЭН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ | | | | | | | | | | | | | | |
| 11 | Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаа хийх | 2024-2027 | Улсын төсөв ЭМДС ОУБ | 90.0 сая | - | Зонхилон тохиолдлох сэтгэцийн эмгэгийн тархалтыг үнэлэх арга аргачлалыг боловсруулж, судалгааг эхлүүлсэн байна | 10.0 | Баруун бүсийн 3, зүүн бүсийн 3, төвийн бүсийн 3 аймагт судалгааны ажил хийгдсэн байна. | 50.0 | Хангайн бүсийн 5 аймаг, Улаанбаатарын бүсэд судалгааны ажил хийгдсэн байна | 30.0 | Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тогтолцоог үнэлэх судалгааны тайлан, зөвлөмж гарсан байна | - | СЭМҮТ Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар | НЭМҮТ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| 12 | Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр эрдэм шинжилгээний хурал, үндэсний болон олон улсын чуулганыг зохион байгуулах | 2024-2027 | ДЭМБ | 400.0 | Үндэсний анхдугаар чуулган 2022 | Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдсан байна | 100.0 | - | | Эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдсан байна | 100.0 | ОУ-ын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан байна | 200.0 | ЭМЯ, СЭМҮТ АШУҮИС | ХЗДХЯ ГХЯ БШУЯ, БЕГ ТББ |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч, сэтгэлзүйч, багш, нийгмийн ажилтнуудыг сургагч багшаар бэлтгэж, эцэг, эх хүүхэдтэйгээ хэрхэн зөв харилцах, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг тогтмол явуулж, үр дүнг тооцох | 2024-2027 | НҮБ-ын Хүүхдийн сан | 170.0 | Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он | 2 дүүрэг, 2 аймгийн хүүхдийн байгууллагын ажилчдад сургалт явуулж, 20 сургагч багш бэлтгэсэн байна | 50.0 | 3 дүүрэг, 6 аймгийн хүүхдийн байгууллагын ажилчдад сургалт явуулж, 30 сургагч багш бэлтгэсэн байна | 20.0 | 3 дүүрэг, 8 аймгийн хүүхдийн байгууллагын ажилчдад сургалт явуулж, 40 сургагч багш бэлтгэсэн байна | 50.0 | Үйл ажиллагааг үнэлж, нэгдсэн тайлан, зөвлөмж гарсан байна. | 50.0 | БСШУЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ СЭМҮТ | ЦХХХЯ ГХУСАЗАА НЭМҮТ |
| 14 | Хүүхдийн байгууллагын орчинд сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх | 2024-2027 | НҮБ-ын Хүүхдийн сан | Орон нутгийн төсөв | Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он | 2 дүүрэг, баруун бүсийн 4 аймгийн хүүхдийн байгууллагад сэтгэцийн эмгэгийн анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг явуулна | Орон нутаг | 2 дүүрэг, зүүн бүсийн 4 аймгийн хүүхдийн байгууллагад сэтгэцийн эмгэгийн анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг явуулна | Орон нутаг | 2 дүүрэг, хангайн бүсийн 4 аймгийн хүүхдийн байгууллагад албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг тандана | Орон нутаг | 2 дүүрэг, төвийн бүсийн 4 аймгийн хүүхдийн байгууллагад албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг тандана | Орон нутаг | Аймаг, нийслэлийн ЗДТГ СЭМҮТ НЭМҮТ | ХНХЯ БСШУЯ ХЗДХЯ ТББ |
| 15 | Хүүхэд, өсвөр үеийг цахим халдлага, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, мансуурах зэрэг хорт зан үйлээс ангид байх нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттай явуулах | 2024-2027 | НҮБ-ын Хүүхдийн сан | 70.0 | "Банхар арт терапи" төсөл, 2019-2021 онд 693 сургагч багш | Үе тэнгийнхний сургагч багш бэлтгэх хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох агуулгыг нэмж, тусган, 100 сургагч багш бэлтгэж, 1 дүүрэг, 2 аймагт нөлөөллийн ажил хийгдсэн байна. | 20.0 | 3 дүүрэг, 6 аймагт нөлөөллийн ажлыг явуулж, 500 сургагч багш бэлтгэсэн байна. | 30.0 | 3 дүүрэг, 12 аймагт нөлөөллийн ажлыг явуулж, бэлтгэсэн сургагч багш нарын гэрчилгээжүүлж үйл ажиллагааны үр дүнгээр нь урамшуулдаг болсон байна | 10.0 | Сургагч багшийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, чадавхжуулах давтан сургалтыг тогтмол явуулж хэвшсэн байна | 10.0 | ЭМЯ-ны СЭЗГ СЭМҮТ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | БШУЯ, ХНХЯ ЦЕГ, НЭМҮТ, ГБХЗХГ, ХБХХЕГ, ХБХСЗТ |
| 16 | Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээлэл, сургалт сурталчилгааны агуулгад дүн шинжилгээ хийж, өсвөр насны хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд, төлөвшилд нөлөөлж буй эсэхийг тандан судлах | 2024-2027 | НҮБ-ын Хүүхдийн сан | 20.0 | - | Судалгааны арга аргачлал боловсруулж, цахим сүлжээгээр дамжуулагдаж буй мэдээлэл, сурталчилгааны агуулгад дүн шинжилгээ хийсэн байна. | - | Олон нийтийн телевизээр мэдээлэгдэж буй сургалт, сурталчилгаанд дүн шинжилгээ хийсэн байна | 20.0 | Өсвөр насны хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд, төлөвшилд нөлөөлж буй эсэхийг тодорхойлсон байна | - | Дүн шинжилгээний тайлан, зөвлөмж гарсан байна | - | ЭМЯ, БШУЯ, ЦХХХЯ, СЯ | СЭМҮТ НЭМҮТ ЦЕГ МСНЭ, ТББ |
| 17 | Сэтгэцийн эрүүл мэнд болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээллийг хүүхэд өсвөр үеийн онцлог хэрэгцээнд нь тохирсон байдлаар хүргэх, тэдний идэвхтэй ашигладаг мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх ажлыг зохион байгуулах | 2024-2027 | НҮБ-ын Хүүхдийн сан | 50.0 | СЭМҮТ-ийн цахим хуудас дахь хандалтын тоо 51,611 | Хүүхэд бүрийн сонирхол, онцлог хэрэгцээнд нь тулгуурлан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим хуудас, инстаграм, фейсбүүкийг тогтмол ажиллуулдаг болсон байна | 40.0 | Цахим хуудсаар дамжуулан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэх, сэтгэл зүйн зөвлөгөө 100,000 хүүхдэд хүргэж ажилласан байна | 10.0 | Цахим хуудсаар дамжуулан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, гэмт хэрэгт өртөхөөс сэргийлэх, сэтгэл зүйн зөвлөгөө 200,000 хүүхдэд хүргэж ажилласан байна | - | Цахим хуудас, инстаграм, фейсбүүкээр зөвлөгөө мэдээлэл авсан хүүхдийн сэтгэлзүйн байдалд тандалт хийж, хариу арга хэмжээг авдаг болсон байна. | - | ГХУСАЗЗАА ЭМЯ, СЭМҮТ НЭМҮТ | НЭМҮТ, ЦЕГ, ГБХЗХГ, ХХЗХ, АНЗДТГ, ЗХТ, ТББ |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих, урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн цахим орчинд нөлөөллийн ажлууд зохион байгуулах | 2024-2027 | ОУБ ЭМДС | 400.0 | Цахим орчин дахь хандалтын тоо | Иргэдэд СЭМ-ийн боловсрол олгох зорилгоор видео шторк, контент, постер бэлтгэж, үндэсний хэмжээнд нөлөөллийн ажил зохион байгуулах | 200.0 | Нөлөөллийн ажлыг зохион байгуулж үндэсний хэмжээнд түгээж, цахим хуудас дахь хандалтын тоо 20%-иар өссөн байна | 100.0 | Мэдээллийн хүртээмж нэмэгдүүлж цахим хуудас дахь хандалтын тоо 40%-иар өссөн байна | 50.0 | Мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, цахим хуудас дахь хандалтын тоо 80%-иар өссөн байна | 50.0 | ЭМЯ-ны НЭМГ, ЦХХХЯ СЭМҮТ НЭМҮТ | НЭМҮТ НЗДТГ, АЗДТГ, ЗХТ, |
| 19 | Аж ахуйн нэгж байгууллагуудын албан хаагчдад архи, согтууруулах ундаа, электрон болон утаат тамхи, дам тамхидалтын хор нөлөөг таниулах сурталчлах, соён гэгээрүүлэх, ухуулга нөлөөллийн ажлыг эрчимжүүлж, төрийн болон ТББ, олон нийтийн хөдөлгөөнийг дэмжих ажлыг зохион байгуулах | 2024-2027 | ДЭМБ ОУБ ЭМДС | 126.0 | Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилт | Зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөө батлуулж, 50 байгууллагад нөлөөллийн ажлыг явуулсан байна. | 50.0 | Төлөвлөгөөг 200- гаас дээш ажилтантай 100 байгууллагад хэрэгжүүлж, нөлөөллийн ажлыг явуулсан байна. | 50.0 | Төлөвлөгөөг 200-аас дээш ажилтантай 200 байгууллагад хэрэгжүүлж, нөлөөллийн ажлыг явуулсан байна | 26.0 | Төлөвлөгөөг 200-аас дээш ажилтантай 300 байгууллагад хэрэгжүүлж, нөлөөллийн ажлыг явуулсан байна | - | ЭМЯ-ны НЭМГ, СЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ | МУТЕГ ХНХЯ ХЗДХЯ ЦЕГ НЭМҮТ АНЭМГ ЗХТ |
| 20 | Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, сэтгэцийн эмгэгийн тухай нийгэм дэх ташаа ойлголт, хандлагыг өөрчлөх ухуулга нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 2024-2027 | ЭМДС | 20.0 | - | Зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөө баталж хэрэгжүүлж эхэлсэн байна | 5.0 | Сэтгэцийн эмгэгийн тухай нийгэм дэх ташаа ойлголт, хандлагыг өөрчлөх 4 арга хэмжээг явуулсан байна | 5.0 | Сэтгэцийн эмгэгийн тухай нийгэм дэх ташаа ойлголт, хандлагыг өөрчлөх 4 арга хэмжээг явуулсан байна | 5.0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, хариу арга хэмжээг авсан байна | 5.0 | ЭМЯ-ны НЭМГ, СЭМҮТ НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ | ХЗДХЯ, ХНХЯ, НЭМҮТ, МУХЭҮК, ЖҮХ |
| 21 | Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх сургагч багш болон сайн дурын ажилтан бэлтгэх | 2024-2027 | ОУБ | 246.0 | Эрүүл мэндийн сайдын А/672 тушаал | Гамшгийн үед нийгэм, сэтгэц-зан үйлийг төлөвшүүлэх сургагч багшаар 300 эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэж, гарын авлагаар хангана | 63.0 | Гамшгийн үед нийгэм, сэтгэц-зан үйлийг төлөвшүүлэх сургагч багшаар 300 сайн дурын бэлтгэж, гарын авлагаар хангана | 15.0 | Гамшгийн үед нийгэм, сэтгэц-зан үйлийг төлөвшүүлэх сургагч багшаар 500 сайн дурын бэлтгэж, гарын авлагаар хангана | 68.0 | Сургагч багш нарыг үнэлж, бүртгэлжүүлж, давтан сургалтыг явуулсан байна | 100.0 | ЭМЯ, БШУЯ ОБЕГ СЭМҮТ | АНЗДТГ, АНЭМГ, БЕГ МУЗН, Монгол дахь ЭТК ЗХТ ТББ |
| 22 | Аутизмыг эрт оношлох, аутизмтай хүнийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох, нийгэмшүүлэх | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 278.0 | Эрүүл мэндийн тухай хуулийн 8.7, Боловсролын ерөнхий хуулийн 17.9 | Аутизм өвчнийг эрт илрүүлэх сэтгэл зүйн оношилгооны шинэ технологийг нэвтрүүлж, Хүүхдийн сэргээн засах төвийг түшиглэн "Аутизмын төв"-ийг байгуулсан байна | 70.0 | Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээтэй хослуулан үзүүлэх хамтарсан дүрэм, журмыг батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | 70.0 | Сэтгэцийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж бэлтгэн, Зүүн бүсэд 1 төв/тасаг, нэгжийг байгуулсан байна | 70.0 | Аутизмтай хүнийг хүчирхэгжүүлэх, амьдрах ухааны ур чадвар олгох, нийгэмшүүлэх ажлын ур дүнг тооцож тайлагнасан байна | 65.0 | ЭМЯ-ны БТГ, СЭЗГ, ХНХЯ СЯ ЭМДЕГ | ЭМБ |
| 23 | Аймаг, нийслэлийн хүүхэд, өсвөр үеийн кабинетын эмч эмнэлгийн мэргэжилтнийг сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх чадамж эзэмшүүлэх | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 160.0 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль | Баруун бүсийн аймгуудын хүүхдийн эмч, өсвөр үеийн кабинетын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан байна | 40.0 | Зүүн болон хангайн бүсийн аймгуудын хүүхдийн эмч, өсвөр үеийн кабинетын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан байна | 40.0 | Улаанбаатар болон Төвийн бүсийн аймгуудын хүүхдийн эмч, өсвөр үеийн кабинетын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан байна | 40.0 | Сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлдэг болсон байна | 40.0 | СЭМҮТ Аймаг, нийслэлийн ЭМГ | ЭМБ |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | Оюутны дотуур байр, хүүхдийн зуслан, амралтын газруудад сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандах, хянах ажлыг тогтмол хийх (буруу зан үйлд нөлөөлөх байдлыг тандах) | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 160.0 | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль | Хүүхдийн зуслангуудад сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйл явагдах боломжтой эсэхийг тандах, судална | 40.0 | Оюутны дотуур байранд сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйл явагдах боломжтой эсэхийг тандах, судална | 40.0 | Амралтын газруудад сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйл явагдах боломжтой эсэхийг тандах, судална | 40.0 | Тандалт судалгааны тайлан, зөвлөмж гарсан байна | 40.0 | Аймаг, нийслэлийн ЗДТГ СЭМҮТ | Хүүхдийн зуслан, Аж ахуйн нэгж |
| 3. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ, ЭМЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ӨРГӨЖҮҮЛЭХ | | | | | | | | | | | | | | | |
| 25 | Аймаг, дүүрэгт сэтгэцийн эмгэгтэй хүний хэрэгцээ, чадамжийг харгалзан гэр бүл, орон нутагт нь ойр байлгаж, амьдрах ур чадварыг нь дэмжиж, чиглэсэн сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах нэгж байгуулах | 2024-2027 | Улсын төсөв | Орон нутгийн төсөв | Сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх 10 нэгж | Төсвийн зардлыг шийдвэрлүүлж, сэтгэц нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх нэгжийг 2 аймагт байгуулна | - | Сэтгэц, нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх нэгжийг 2 дүүрэг 8 аймагт байгуулна | - | Сэтгэц, нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх нэгжийг 2 дүүрэг 16 аймагт байгуулна | - | Нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тогтмол явуулдаг болсон байна | Орон нутаг | ЭМЯ, СЯ ХНХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ | ХБХХЕГ, ХБХСЗХТ СЭМҮТ ТББ |
| 26 | ДЭМБ-ын Сэтгэц, мэдрэл, донтолтын үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хөтөлбөр /mhGAP/-ийг өргөжүүлэх | 2024-2027 | ДЭМБ | 500.0 | Нийслэлийн 2 дүүрэг, 7 аймгийн нийт 317 эмч, мэргэжилтэн | Сэтгэц, мэдрэл, донтолтын ДЭМБ-ын "mhGAP" төслийг төвийн бүсийн аймгуудад хэрэгжүүлсэн байна | 100.0 | Улаанбаатарын бүс, зүүн бүсийн аймгуудад төслийг хэрэгжүүлсэн байна | 150.0 | Баруун бүсийн аймгуудад төслийг хэрэгжүүлсэн байна | 150.0 | Хангайн бүсийн аймгуудад төслийг хэрэгжүүлсэн байна | 100.0 | ЭМЯ СЭМҮТ | АНЭМГ |
| 27 | Архидан согтуурахаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил, хүчирхийллийг бууруулах үүднээс ард иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжид чиглэсэн архинаас гаргах зорилго бүхий төслийг жил бүр улсын хэмжээнд зохион байгуулах | 2024-2027 | АСТУСУ АДС | 4.8 тэрбум | Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгаас эмчилгээнд хамрагдсан хүний тоо | Минесота загвараар 21 аймаг, 9 дүүрэг тус бүрээс архины хамааралтай 30 иргэнийг 3 сар эмчилнэ. Нийт 90 хүн хамруулсан байна | 1,2 тэрбум | 21 аймаг, 9 дүүрэг тус бүрт 30 хамааралтай иргэнийг Минесота загвараар 3 сар эмчилнэ. Нийт 90 хүн хамруулсан байна . | 1,2 тэрбум | 21 аймаг, 9 дүүрэг тус бүрт 30 хамааралтай иргэнийг Минесота загвараар 3 сар эмчилнэ. Нийт 90 хүн хамруулсан байна | 1,2 тэрбум | 21 аймаг, 9 дүүрэгт хэрэгжсэн эмчилгээний үр дүнгээ тооцож, "Итгэл" төслийг үнэлнэ. | 1,2 тэрбум | ХЗДХЯ ЭМЯ ХНХЯ СЭМҮТ<br><br>Аймаг, нийслэлийн ЗДТГ | ЦЕГ АНЭМГ Аддиктологийн төв |
| 28 | Мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жор бичилтийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг зохион байгуулах, эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх | 2024-2027 | Улсын төсөв | - | ЭМС-ын 2020 А/495 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жор бичилтийг цахимжуулж, хяналт тавих журмын төслийг боловсруулж, батлуулсан байна | - | Цахим жорын систем ашиглах талаарх сургалт зохион байгуулсан байна | - | Цахим жорын систем тогтвортой үйл ажиллагаа нэгдсэн зохицуулалтаар хангагдсан байна | - | Цахим жорын систем тогтвортой үйл ажиллагаа нэгдсэн зохицуулалтаар хангагдсан байна. | - | ХЗДХЯ ЦХХХЯ ЭМЯ-ны БТГ, ЭЭХХЗГ ЭМДЕГ СЭМҮТ | ТЕГ АНЭМГ ХТТГ |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 29 | Ахмад настны сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах | 2024-2027 | Улсын төсөв ЭМДС ОУБ | - | Эрүүл мэндийн сайдын А/517 дугаар тушаал | ЭМС-ын А/517 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургаж ур чадварыг сайжруулсан байна. | - | Тэтгэвэрт гарахын өмнө болон гарсны дараах сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх сургалтын төв, дамжаа, ангийг үүсгэн байгуулж, сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтыг тогтмол зохион байгуулдаг болсон байна | - | Настанд ээлтэй сэтгэцийн эрүүл мэндийг дэмжигч, хамгаалагч дүүрэг, сум, хороо, баг, аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байрыг бий болгосон байна. | - | Сайн туршлагын талаар орон нутагт өндөр настанд зориулсан явуулын сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог зохион байгуулсан байна | - | Бүх яам, Аймаг, нийслэлийн ЗДТГ<br>СЭМҮТ НЭМҮТ ГҮТ | АНЭМГ ТББ ОУБ |
| 30 | Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгээс сэргийлэх, тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 350.0 | Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаа, 2019 он | Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийг түшиглэн "Нойргүйдлийн төв"-ийг байгуулсан байна | 100.0 | Сэтгэцэд зонхилон тохиолдох 6 бүлэг эмгэгийг эрт илрүүлэх, оношлох, анхан шатны зөвлөгөө өгөх ур чадвар, хандлагыг сайжруулах сургалтыг тогтмол явуулдаг болсон байна | 100.0 | Сэтгэцэд зонхилон тохиолдох эмгэгээс сэргийлэх зөвлөмж, мэдээллийг тогтмол хүргэж, оношилгоо эмчилгээ хийдэг болсон байна | 80.0 | Тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах, үйл ажиллагаа нь тогтмол дэмжиж ажилласан байна. | 70.0 | СЭМҮТ<br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар | ЭМБ |
| 30 | Сэтгэц идэвхт эм, бодис болон мансууруулах, донтох, наркотик бодисын хамааралтай эмгэгийн эмчлэх | 2024-2027 | Улсын төсөв ОУБ | 350.0 | - | Архи, мансууруулах эм, сэтгэц идэвхт бодисын хэрэглээ хамаарлын судалгаа хийж, хамаарал бүхий иргэдийн судалгаа гаргана | 87.5 | Донтох, мансуурлын эсрэг тасаг, нэгжийг Аддектологийн төвийг түшиглэн байгуулж, архи болон мансууруулах эм, сэтгэц идэвхт бодисын хэрэглээг бууруулах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ | 87.5 | Наркотик бодис хэрэглэх хорт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулдаг болсон байна | 87.5 | Хорт зуршлаас сэргийлэх арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулдаг болсон байна | 87.5 | СЭМҮТ<br>Цэргийн төв эмнэлгийн Хорлогын яаралтай тусламжийн үндэсний төв | АНЭМГ |

4.СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ ЭМЧ, ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ НИЙЦҮҮЛЭН СУРГАХ, ХӨГЖҮҮЛЭХ, МЭРГЭШҮҮЛЭХ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА, СТАНДАРТЫГ ХАНГАХ, ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИНД АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | Мансуурлын эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн Коломбо хөтөлбөрийн сургалтад эмч нарыг хамруулж сургагч багш бэлтгэх ажлыг зохион байгуулах | 2024-2027 | ОУБ | 200.0 | 18 багш | "Colombo plan" төслийн сургалтын ахисан түвшний сургалт явуулах эрхийг авч, үндэсний сургагч багшийн тоог 38 багшаар нэмэгдүүлнэ | - | Хөтөлбөрийн суурь түвшний сургалтад хамрагдсан эмч нар ахисан түвшний сургалтад хамрагдан сургагч багш 58 болсон байна | 200.0 | Бэлтгэгдсэн үндэсний сургагч багш нар бусад мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалтыг зохион байгуулсан байна | - | - | - | ГХУСАЗАА, ЦЕГ | ЭМЯ СЭМҮТ |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг олон улсын сургалтын хөтөлбөрийн дагуу боловсруулж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэж, чадавхжуулах | 2024-2027 | ОУБ | 200.0 | 2 | Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг дэлхийн нийтийн сургалтын чиг хандлагад нийцүүлэн боловсруулж, батлуулсан байна | - | Донтолт судлал, сэтгэл засал судлал, шүүхийн сэтгэц судлал, хүүхэд, өсвөр үеийн сэтгэц судлалаар төрөлжсөн нарийн мэргэшлийн эмч нарыг 50% нэмэгдүүлж бэлтгэсэн байна | 100.0 | Донтолт судлал, сэтгэл засал судлал, шүүхийн сэтгэц судлал, хүүхэд, өсвөр үеийн сэтгэц судлалаар төрөлжсөн нарийн мэргэшлийн эмч нарыг 80% нэмэгдүүлж бэлтгэсэн байна | 100.0 | Төрөлжсөн мэргэшлийн эмч нарын тоо 2 дахин нэмэгдүүлж, бэлтгэсэн байна | - | СЭМҮТ ЭМХТ АШУҮИС | АНЭМГ |
| 33 | Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч/даван туулагсдад үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх арга зүйд сургах | 2024-2027 | Улсын төсөв, ОУБ | 200.0 | Хүүхдийн сангийн Багц гарын авлагын 11 дэх модуль сургалт | Улаанбаатарын бүсийн эмч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэнг сургаж бэлтгэсэн байна | 50.0 | Баруун болон зүүн бүсийн анхан шатны эрч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэсэн байна | 50.0 | Төвийн болон хангайн бүсийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэсэн байна | 50.0 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний заавал судлах багц цагийн сургалтад тусгаж, сургалт явагддаг болсон байна | 50.0 | СЭМҮТ ЭМХТ АШУҮИС | АНЭМГ |
| 34 | Сэтгэц-нийгмийн сэргээн засах төв, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын сэтгэцийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх арга барил эзэмшүүлж, мэргэшүүлэх | 2024-2027 | Улсын төсөв, ОУБ | 200.0 | Хүүхэд хамгааллын тухай хууль | Улаанбаатарын бүсийн эмч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн нийгмийн ажилтанг сургаж бэлтгэсэн байна | | Баруун болон зүүн бүсийн анхан шатны нийгмийн эрүүл мэндийн ажилтанг сургаж бэлтгэсэн байна | | Төвийн болон хангайн бүсийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ЭМНА-ыг сургаж бэлтгэсэн байна | | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний заавал судлах багц цагийн сургалтад тусгаж, сургалт явагддаг болсон байна | | СЭМҮТ ЭМХТ АШУҮИС | АНЭМГ |

**Товчилсон үгийн жагсаалт:**

МУТЕГ – Монгол улсын Тагнуулын ерөнхий газар
МУҮАБЗ – Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
МУХЭҮК – Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
ГХУСАЗЗАА – Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба
ЖҮХ – Жендэрийн үндэсний хороо
ЗТХЯ – Зам, тээврийн хөгжлийн яам
БХЯ – Батлан хамгаалах яам
СЯ – Сангийн яам
УУХҮЯ – Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

ХЗДХЯ – Хууль зүй, дотоод хэргийн яам
ХТТГ-Хар тамхитай тэмцэх газар
ЦЕГ – Цагдаагийн ерөнхий газар

БШУЯ – Боловсрол, шинжлэх ухааны яам
БЕГ – Боловсролын ерөнхий газар

АШУҮИС – Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БМДИ – Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БСҮХ – Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн
ШУТС – Шинжлэх ухаан технологийн сан
ЕБС – Ерөнхий боловсролын сургууль
СӨБ – Сургуулийн өмнөх боловсрол

ХНХЯ – Хөдөлмөр,нийгмийн хамгааллын яам
ГБХЗХГ – Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ХБХХЕГ - Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХБХСЗТ – Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв
ЗХТ – Залуучуудын хөгжлийн төв

ЭМЯ – Эрүүл мэндийн яам
ЭМДЕГ – Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭЭХХЗГ – Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
ГҮТ-Геронтологийн үндэсний төв
НЭМҮТ – Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
СЭМҮТ – Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМДС – Эрүүл мэндийг дэмжих сан
ЭМХТ – Эрүүл мэндийн хөгжлийн төв

АНЗДТГ – Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
НЗДТГ- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
АЗДТГ – Аймгийн Засаг даргын Тамгын газар
АНЭМГ – Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар

НЭМГ – Нийслэлийн эрүүл мэндийн газар
АЭМГ – Аймгийн эрүүл мэндийн газар

ГҮТ – Геронтологийн үндэсний төв

НБГ – Нийслэлийн Боловсролын газар

ДЭМБ – Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар
МСНЭ – Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл
МУЗН – Монголын улаан загалмай нийгэмлэг
МУСЗМХ – Монголын урлагийн сэтгэл заслын мэргэжлийн холбоо

Монгол дахь ЭТК – Монгол дахь Энх тайвны корпус
НҮБ – Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБ – Нэгдсэн Үндэсний байгууллага
НҮБ-ын ХС – Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн Сан
НҮБ-ын ХАС – Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүн амын Сан

ОУБ – Олон улсын байгууллагууд
СЭМ – Сэтгэцийн эрүүл мэнд
ТББ – Төрийн бус байгууллага
ХНХЯ – Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХЕГ – Хил хамгаалах ерөнхий газар
ХХЗХ – Харилцаа холбооны Зохицуулах Хороо
ЦХХХЯ – Цахим хөгжил, харилцаа холбооны яам
АСТУСҮАДС- Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан

ААНБ – Аж ахуйн нэгж, байгууллага

---oOo---

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 29 өдрийн А/112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД" АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь үзүүлэлт | Хүрэх түвшин | | | | Мэдээллийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2024 он | 2025 он | 2026 он | 2027 он | |
| | 1. Үр нөлөөллийн шалгуур үзүүлэлт | | | | | | | |
| 1. | Үйл ажиллагаа 7: Амиа хорлолтын түвшин | Промиль | 100,000 хүн амд 16,3 | 100,000 хүн амд 16 | 100,000 хүн амд 15.5 | 100,000 хүн амд 15 | 100,000 хүн амд 14,5 | Статистик тайлан |
| 2. | Үйл ажиллагаа 9: Албан ажлын сэтгэл зүйн хэм хэмжээг дэмжиж ажилласан байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага | Тоо | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль | 50 | 100 | 200 | 300 | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын тайлан |
| 3. | Үйл ажиллагаа 13: Хүүхэд, өсвөр үеийн сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн талаар зөв дадал эзэмшсэн эцэг, эх асран хамгаалагчид | Тоо | 2023 онд зөв дадал эзэмшсэн хүн | 50-аар нэмэгдэнэ | 150-аар нэмэгдэнэ | 250-аар нэмэгдэнэ | 350-аар нэмэгдэнэ | БСШУЯ-ны үйл ажиллагааны тайлан |
| 4. | Үйл ажиллагаа 19: Архи, согтууруулах ундаа, электрон болон утаат тамхи, дам тамхидалтын хор нөлөөг таниулах сурталчлах, соён гэгээрүүлэх арга хэмжээнд хамрагдсан байгууллагын хорт зуршлаас татгалзсан хүн | Тоо | Тамхины хяналтын тухай хууль | , 40 | 100 | 200 | 300 | АНЗДТГ-аас болон СЭМҮТ-ийн тайлан, статистик |
| 5. | Үйл ажиллагаа 19: Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг ТББ | Тоо | 25 | 30 | 35 | 40 | 45 | |
| 6. | Үйл ажиллагаа 22: Амьдрах ур чадварт сургасан сэтгэцийн эмгэгтэй хүн | Тоо | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль | 50 | 100 | 100 | 100 | СЭМҮТ-ийн статистик тайлан |
| 7. | Үйл ажиллагаа 23: Сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх чадамж эзэмшсэн хүүхэд, өсвөр үеийн эмч | Тоо | 6 | 16 | 26 | 36 | 46 | ЭМХТ-ийн болон Аймаг, нийслэлийн ЭМГ-ын статистик тайлан |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Үйл ажиллагаа 27: Архинаас гарах төсөлд хамрагдан дадал хэвшлээ өөрчилсөн хүн | тоо | - | 90 хүн | 90 хүн | 90 хүн | "Итгэл" төслийг үнэлнэ. | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын тайлан |
| 9. | Үйл ажиллагаа 33: Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх арга зүй эзэмшсэн эмч, мэргэжилтэн | хувь | 3 дүүрэг, 11 аймаг | 3 дүүрэг, 15 аймаг | 3 дүүрэг, 18 аймаг | 3 дүүрэг, 19 аймаг | 3 дүүрэг, 21 аймаг | ЭМХТ-ийн статистик, мэдээлэл, СЭМҮТ-ийн тайлан |
| **2. Үр дүнгийн шалгуур үзүүлэлт** | | | | | | | | |
| 10. | Үйл ажиллагаа 5: Эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж буй сэтгэл зүйч | тоо | 25 | 30 | 40 | 50 | 60 | ЭМХТ-ийн статистик мэдээлэл |
| 11. | Үйл ажиллагаа 5: Аймаг, дүүргийн түвшинд ажилладаг сэтгэцийн эмч | тоо | 56 | 58 | 60 | 62 | 54 | ЭМХТ-ийн статистик мэдээлэл |
| 12. | Үйл ажиллагаа 6: Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тусламж, үйлчилгээний хэвтүүлэн эмчлэх ор | тоо | 281 | 285 | 290 | 292 | 296 | ЭМХТ, ЭМДЕГ-ийн статистик мэдээлэл |
| 13. | Үйл ажиллагаа 13: Эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэгдсэн багш, эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан | тоо | Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он | 20 | 30 | 40 | нэгдсэн тайлан, зөвлөмж | БСШУЯ-ны статистик мэдээлэл, СЭМҮТ-ийн тайлан |
| 14. | Үйл ажиллагаа 13: Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад хамрагдсан эцэг, эх асран хамгаалагчид | тоо | | 1000 | 2000 | 30000 | 4000 | Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ-ын тайлан |
| 15. | Үйл ажиллагаа 13: Сургуулийн орчинд ажиллах сэтгэл зүйч | хувь | 151 | 10% | 20% | 30% | 40% | БСШУЯ-ны статистик мэдээлэл |
| 16. | Үйл ажиллагаа 14: Хүүхдийн байгууллагын орчин дахь сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах цогц арга хэмжээний тоо | | Боловсролын орчин дахь хүүхдийн эрх хамгааллын судалгаа 2023 он | 2 дүүрэг, баруун бүсийн 4 аймаг | 2 дүүрэг, зүүн бүсийн 4 аймаг | 2 дүүрэг, хангайн бүсийн 4 аймаг | 2 дүүрэг, төвийн бүсийн 4 аймаг | Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын болон СЭМҮТ-ийн тайлан |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17. | Үйл ажиллагаа 25: Аймаг дүүргийн хэмжээнд сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх төв, тасаг, нэгж | тоо | 8 | 10 | 12 | 14 | 16 | Статистик мэдээлэл |
| 18. | Үйл ажиллагаа 25: Аймаг дүүргийн хэмжээнд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлдэг болсон төв, тасаг, нэгж | тоо | 8 | 10 | 12 | 14 | 16 | Статистик мэдээлэл |
| 19. | Үйл ажиллагаа 27: Архинд донтох эмгэгийн эмчилгээнд хамрагдалт | хувь | 28,7% | 30% | 35% | 45% | 50% | Эрүүл мэндийн үзүүлэлт |
| 20. | Үйл ажиллагаа 28: Анхан шатлалд СЭМ-ийн чиглэлээр тусламж, үйлчилгээ авсан хүн | хувь /тоо | 28,450 | 5% | 10% | 15% | 20% | Аймаг, нийслэлийн ЭМГ-ын статистик тайлан, ЭМДС-ын санхүүжилт |
| 21. | Үйл ажиллагаа 28: Зайлшгүй шаардлагатай эмийн үндэсний жагсаалтад орсон сэтгэц нөлөөт эмийн тоо/төрөл | төрөл /тоо | 24 | 25 | 26 | - | - | ЗШЭ-ийн 9 дахь жагсаалт |
| 22. | Үйл ажиллагаа 28: Хөнгөлөлтэй эмийн жагсаалтад орсон сэтгэц нөлөөт эмийн тоо, төрөл | тоо | 10 | 11 | 13 | - | - | ЭМДҮЗ 2022.07.04 тогтоол 11 |
| 23. | Үйл ажиллагаа 30: Мансууруулах бодист донтох эмгэгийн эмчилгээний хамрагдалт | хувь | 43% | 45% | 48% | 50% | 55% | Эрүүл мэндийн үзүүлэлт |
| 24. | Үйл ажиллагаа 31: Коломбо хөтөлбөрийн ахисан түвшний сургалтад хамрагдсан сургагч багш | тоо | 18 багш | 38 | 58 | 68 | 70 | СЭМҮТ-ийн статистик тайлан |
| 25. | Үйл ажиллагаа 32: Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадавхад суралцсан сэтгэл засалч | тоо | 58 | 68 | 78 | 88 | 98 | ЭМХТ-ийн статистик тоо |
| 26. | Үйл ажиллагаа 32: Сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн олон улсын сургалтын хөтөлбөрт хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн | тоо | 147 | - | 50% нэмэгдүүлж бэлтгэсэн байна. | 80% нэмэгдүүлж бэлтгэсэн байна. | 2 дахин нэмэгдүүлж, бэлтгэсэн байна. | ЭМХТ-ийн статистик тоо |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27. | Үйл ажиллагаа 32: Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чадавхжуулах сургалтад хамрагдсан шүүх шинжилгээний эмч | тоо | 14 | 16 | 18 | 20 | 22 | ЭМХТ-ийн статистик тоо |
| 28. | Үйл ажиллагаа 32: Донтох эмгэг судлалаар мэргэшсэн эмч | тоо | 38 | 43 | 48 | 53 | 58 | ЭМХТ-ийн статистик тоо |
| 29. | Үйл ажиллагаа 34 Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн нийгмийн ажилтан | тоо | - | 100 | 150 | 200 | 300 | ЭМХТ-ийн статистик тоо |

---oOo---